

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

Жил бүрийн 4 дүгээр сарын 23-ны өдрийг дэлхийн номын өдөр болгон тэмдэглэдэг уламжлалтай билээ. Тэгвэл эл өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн алба хаагчдын төлөөлөл "Ном бидний нөхөр" сэдэвт цахим уулзалтыг санаачлан зохион байгуулав. Уулзалтад

Философийн ухааны доктор (Ph.D) профессор, гавьяат багш Б.Галиндэв, Батлан хамгаалахын "Соёмбо" редакцын дарга, ерөнхий редактор, хурандаа С.Төмөрхуяг, ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа Н.Хүдэрбат, ҮБХИС-ийн төв номын сангийн захирал Ц.Мягмарсүрэн, "Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн, "Аз Хур" ХХК, "Болор-судар" хэвлэлийн

ДЭЛХИЙН НОМЫН ӨДРӨӨР...

газрын эрхлэгч Б.Уранболор болон тус ангид алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчид, тэдний эцэг, эхийн төлөөлөл оролцсон юм. Тэд номтой нөхөрлөхийн ач тус, хүүхэд залууст номоор дамжуулан цэрэг, эх оронч үзэл хүмүүжлийг хэрхэн төлөвшүүлэх, анги, байгууллагуудын номын санг цэргийн алба хаагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн номуудаар яаж баяжуулах, сүүлийн үед ямар номууд бэстселлер болж байгаа вэ зэрэг өргөн хүрээнд ярилцсаны зэрэгцээ бидэнд хэрэгтэй санал зөвлөмжүүдийг ч өгсөн юм. Мөн хугацаат цэргийн алба хаагчдын сонирхсон асуултаудад хариулт өгч,




харилцан ярилцлаа.

Ном уншихын ач тусыг хугацаат цэргийн алба хаагчдад ухуулж ойлгуулах, улмаар тэдэнд номыг эрхэмлэн дээдэлж, шимтэн уншдаг дадал зуршил, ухамсрыг төлөвшүүлэх зорилгоор энэхүү цахим уулзалтыг зохион байгуулсан нь ийнхүү үр дүнтэй боллоо.

XIX зууны Монголын уран зохиолын нэрт төлөөлөгч, нэрт зохиолч В.Инжнанах нэгэнтээ "Ном бол хөгшрөхийн цагт хамгийн сайн нөхөр, залуу явахад хамгийн сайн багш юм" хэмээсэн байдаг билээ. Үнэхээр л ном хэмээх багшийн

ач тус, учир утгыг ухаж ойлгохыг эрмэлзсэн хугацаат цэргийн алба хаагчдынхаа мэдлэгт бага ч гэсэн хөрөнгө оруулсан уулзалт болов. Дашрамд дурдахад, уулзалтын үеэр гавьяат багш Д.Галиндэв дэлхийн сонгодог уран зохиолын ном уншихын хэрэг тусын тухай ярихдаа "Кино үзэх, ном унших хоёр хүний оюуны хөгжилд өдөр, шөнө шиг ялгаатай нөлөө үзүүлнэ. Орчин үед уншигч зохиолчийн байранд гэдэг ойлголт бий болсон байна" гэдгийг онцолж байлаа.

Дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН




“ЭРДМИЙН ИХ ЧУУЛГАН-2021” АНХ УДАА ЦАХИМААР ЗОХИОГДЛОО

ҮБХИС-ийн багш, суралцагчдын “Эрдмийн их чуулган” жил бүр тэнхим, бүрэлдэхүүн сургууль, их сургуулийн түвшинд гэсэн 3 үе шаттай явагддаг.

Хуралд урилгаар БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Содномцог, ҮБХИС-ийн захирал, профессор, бригадын генерал П.Жаргалан, Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, эрдэм шинжилгээний түншлэл хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг болон тус сургуулийн Эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөлийн гишүүд оролцлоо.

Цахим хурлаар харьяаллын сургуулийн эрдэм шинжилгээний хурлын явц, тайланг видео хэлбэрээр бэлтгэн үзүүлж, инновацийн цахим үзэсгэлэнг нийтэд танилцуулав. ҮБХИС-ийн захирлын тушаалаар томилгогдсон комиссын бүрэлдэхүүн харьяаллын сургуулиас шалгарсан эрдэм шинжилгээний илтгэл, шилдэг бүтээл, инновацийн бүтээгдэхүүнээс их сургуулийн хэмжээний шилдгүүдийг шалгаруулсан байна. Байгаль, техникийн ухааны сэдвээр багш нарын төрөлд тэргүүн байрт ЦНДС-ийн АЦТ-ийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Дунгармаа “Радиолокаторын талбайг байгуулах аргачлал” илтгэлээр, дэд байрт ЦНДС-ийн ЦИХТ-ийн багш, ахмад Б.Баярбаясгалан “Цэргийн зам барих ажлыг сайжруулах технологид хийсэн судалгаа” илтгэлээр, тусгай байрт ЦХК-ийн ХУТ-ийн дарга, дэд



хурандаа Б.Анхбаяр “Цэргийн хөгжмийн урын сангийн судалгаа” илтгэлээр тус тус шалгарав.

Нийгэм, цэргийн ухааны сэдвээр багш нараас БХМСҮТ-ийн МОСТ-ийн сургагч, сургагч ахлагч Э.Энхтайван “ХБНГУ-ын хуурай замын явган цэргийн Ахлагчийн сургуулийн сургалтын тогтолцоо” илтгэлээр тэргүүлж, АБДС-ийн ММТТ-ийн багш Н.Амаржаргал, Д.Долгормаа, Ц.Хонгорзул нар “Цахим хичээл зохион байгуулалтад хийсэн дүн шинжилгээ” илтгэлээр удаалж, ГХСТ-ийн ахлах багш Р.Онон “Монгол Улсад гадаад хэлний ном, сурах бичиг зохиож ирсэн уламжлал, туршлага, арга зүйн асуудалд” илтгэлээр тусгай байрт тус тус шалгарсан юм. Шилдэг бүтээлийн төрөлд ЦНДС-ийн АЗТ-ийн багш, ахмад Б.Лхагважав “Артиллерийн

буудлагын тавилт тодорхойлох ажиллагааг автоматжуулах арга зам” бүтээлээрээ бусдыгаа манлайлав.

Докторант, магистрантуудаас тэргүүн байрт Аюулгүй байдал судлалын докторант Ц.Буянцогтоо “Энэтхэг-Номхон далайн стратегийн өнөөгийн байдал, цаашдын хандлага” илтгэлээр шалгарч, удаах байрт Цэргийн сэтгэл зүйн хангалтын магистрант, ахмад Б.Баярчимэг “Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын сэтгэцийн байдалд нөлөөлж буй зарим асуудал” илтгэлээр, гуравдугаар байрт Аюулгүй байдал судлалын докторант Н.Соёлгэрэл “Олон улсын харилцаа, бүс нутгийн геополитикийн орчны өөрчлөлтөд хийсэн судалгаа, дүн шинжилгээ” илтгэлээр тус тус шалгарсан юм.

Сонсогч, оюутны байгаль, техникийн ухааны сэдвээр эхний байрт АБДС-ийн ЭТ Ф-410 бүлгийн оюутан О.Энхцэцгийн “Нисгэгчгүй нисэх хэрэгслийн загварчлал” илтгэл шалгарлаа. Удаах байрт ЦНДС-ийн ЦАТТ-ийн IV дамжааны сонсогч Х.Түмэндэмбэрэл, ахлах дэслэгч Б.Цэрэнчимэд нарын “Биохийг цэргийн гал тогоонд ашиглах боломжийн судалгаа” илтгэл тодорч, АБДС-ийн ЭЗМТ-ийн М1-302 бүлэг оюутан З.Эрдэнэбаатар, Т.Бямбажаргал нарын “Оюутан цахим орчинд суралцахуйн боломж, давуу тал” илтгэл тусгай байрт шалгарсан юм.

Нийгэм, цэргийн ухааны сэдвээр тэргүүн байрт ЦХК-ийн хөгжмийн 3 дугаар ангийн сонсогч Х.Соёл-Эрдэнэ “Хөгжим” илтгэл, удаах байрт ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн САБ ангийн сонсогч Д.Ууганбатын “Байгууллагын дотоод сүлжээнд халдлага илрүүлэх” илтгэл шалгарч, ЦХК-ийн хөгжмийн 4 дүгээр ангийн сонсогч Х.Өлзийдэлгэрийн “Flute & baetbox гэж юу вэ” илтгэл тусгай байрыг эзэллээ.

Чуулганы үеэр ҮБХИС-ийн захирлын нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг бүтээлээр АБДС-ийн ЭТ-ийн Ф-410 бүлгийн оюутан Б.Сумъяадэлгэрийн “Робот гарын загварчлал” бүтээл, захирлын нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн удирдагчаар АБДС-ийн ЭТ-ийн багш Ч.Нацагням шалгарав.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН ХЭЛТЭС

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 0	🌙 -4
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌙 22
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	🌙 12

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.386.00	3.497.00
CNY 🇨🇳	436.50	441.40
RUB 🇷🇺	36.80	39.50
JPY 🇯🇵	25.93	26.83
KRW 🇰🇷	2.42	2.65

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 14
2021.04.26.
/ДАВАА ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН ЕСӨН УЛААН
ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал арвидна.
Наран ургах, шингэх:
05.43-19.57
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Сэрэхүй
Суудал:
Ус.

Аргын тооллын 4 дүгээр сарын 26, Сумъяа гараа. Билгийн тооллын 14, Тэргүүн дагуул одтой, хөх луу өдөр. Өдрийн наран 5 цаг 43 минутад мандан, 19 цаг 57 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсоод зүүн зүгт мөрөө гаргавал зохиотой. Үс шинээр үрэгээлэх буюу засуулбал эд, мал арвидна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 29.219+1264	ЭДГЭРСЭН 15.403	НАС БАРСАН 78/8
НИЙТ БАТЛАГДСАН 1901 (17)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 290	ЭДГЭРСЭН 1594

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 145,216,414
Эдгэрсэн Нийт: 125,041,307
Нас барсан Нийт: 3,079,390

ТАНДАЛТ	
ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 64,397 838,569
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 13,058 2,643,658
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 1,256 370,228


ЦАХИМ ШУУДАНД

Узбекистаны нийслэл Ташкент хотноо хүндийн өргөлтийн Ази тивийн аварга шалгаруулах "Ташкент-2021" тэмцээн энэ сарын 19-27-ны өдрүүдэд болж байна.

Өнгөрсөн Бямба гарагт болсон эмэгтэйчүүдийн 87 кг-ын жинд "Алдар" спорт хорооны хүндийн өргөлтийн тамирчин, ДАШТ-ий хошой хүрэл медальт, ОУХМ, ахлах дэслэгч М.Анхцэцэг хүрэл медаль хүртлээ. Тэрээр огцом өргөлтөөр 111 кг, түлхэлттэй өргөлтөөр 136 кг, нийлбэр дүнгээр 247 кг-ыг өргөсөн байна. Ингэснээр тэрээр олимпын эрх авахад ойртоод байна.

Уг тэмцээнд ОУХМ, дасгалжуулагч Ц.Хосбаярын удирдлага дор эмэгтэйчүүдийн 59 кг-д Э.Энхтамир, 71 кг-д Г.Ануужин, -87 кг-д


"АЛДАР"-ЫН М.АНХЦЭЦЭГ



АЗИЙН
АВАРГААС
ХҮРЭЛ
МЕДАЛЬ
ХҮРТЛЭЭ

М.Анхцэцэг, Б.Оюунбаяр, +87 кг-д Э.Билэгсайхан, эрэгтэйчүүдийн 67 кг-д Э.Мөнхдөл, 96 кг-д Б.Цэнд-Аюуш нар оролцож байгаа юм.

ЭНЭ САРЫН 30-НД ИХЭНХ
НУТГААР ДУЛААРНА



салбар уулсаар секундэд 16-18 метр, зарим үед секундэд 24 метр хүртэл ширүүсч, шороон шуурга шуурна.

Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Завхан голын эх, Хүрэнбэлчир орчим, Идэр, Тэс голын хөндийгөөр шөнөдөө 11-16, өдөртөө 0-5, Хэнтэйн уулархаг нутаг, Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул, Тэрэлж, Хэрлэн, Онон, Улз голын хөндийгөөр шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 0-5 хэм дулаан, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө -3-аас 2, өдөртөө 9-14 хэм дулаан, бусад нутгаар шөнөдөө 2-7 хэм хүйтэн, өдөртөө 4-9 хэм дулаан байна. 29-нд нутгийн баруун хэсгээр, 30-нд ихэнх нутгаар дулаарна.

Өнөөдөр Төв аймгийн зүүн өмнөд хэсэг, Хэнтийн нутгаар цасан шуурга шуурч, Өмнөговь, Дундговийн зүүн хэсэг, Дорноговийн нутаг, Сүхбаатарын өмнөд хэсгээр салхи секундэд 18-20 метр, зарим үед секундэд 24 метрийг давж ширүүснэ гэж цаг агаарын

байгууллагаас анхаарууллаа. Энэ сарын 27, 28-нд төвийн аймгуудын нутгийн зүүн хэсэг, зүүн аймгуудын нутгийн зарим газраар, 29-нд Халх голын сав газраар бороо, нойтон цас орж, цасан шуурга шуурна. Салхи 27, 28-нд нутгийн зүүн хэсгээр, 30-нд Алтайн

ЦАГ ҮЕ

ХАМГИЙН ОЙР БАЙРЛАХ ЦЭГТ ОЧИЖ
ВАКЦИНД ХАМРАГДАЖ БОЛНО

"COVID-19" цар тахлын нөхцөл байдлын мэдээллийг тоон болон график хэлбэрээр, орон зайн байрлалаар авах боломжтой боллоо. Иргэн та www.map.nema.gov.mn-д нэвтрэн, өөрт хамгийн ойр байрлах дархлаажуулалтын цэгт очиж вакциндаа хамрагдах боломжтой ажээ.

"COVID-19 ERSDEL" системийг 300 мянган хүн гар утсанд суулгажээ

хугацаанд илүү хурдтай нэвтэрч байна гэж "Google" болон "Apple"-ийн мэргэжилтнүүд онцолсон байна. Манай улсад ойролцоогоор 1 сая орчим хүн ашигласан үед энэ системийг нэвтрүүлсний үр дүн гарч, иргэд өөрсдийгөө хамгаалах боломж үүсэх юм. Ингэснээр эрүүл мэндийн салбарын ажилд томоохон тус нэмэр болох бөгөөд халдварын тархалт эрс буурах боломж бүрдэх аж.

системийг суулгана. Харин iOS үйлдлийн системтэй бол та утасныхаа Settings рүү ороод Exposure Notification-ийг идэвхжүүлээрэй. Ингэхдээ iOS үйлдлийн систем 12.5 эсвэл 13.7 хувилбар эсвэл түүнээс хойших хувилбар дээр Settings тохиргоо хийх боломжтой. Мөн та энэхүү системийг монгол хэлээр ашиглах бол гар утасныхаа системийг хэлийг монгол болгон солих юм.

Хэрэв таны коронавируст халдварын PCR шинжилгээний хариу эерэг гарвал УОК-оос баталгаажуулах линк гар утсанд тань очно. Баталгаажуулах линк дээр дарж, өөрийн мэдээллээ нууцлан халдвар авсан тухайгаа ойрын хавьтлууддаа мэдэгдээрэй. Ингэснээр тантай 2 метрийн зайд 15 минутаас дээш хугацаанд ойр байсан хүмүүст хавьтал болсон талаарх мэдэгдэл ирнэ. Хавьтал болсон иргэд гар утсанд нь ирсэн линк дээр дарж, асуумж бөглөн, өөрийгөө тусгаарлах эсвэл шинжилгээ өгөх эсэхээ шийднэ.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс та Bluetooth-ээ байнга асаалттай байлгах шаардлагатай. Энэ үед таны байршил болон хувийн мэдээллийг цуглуулахгүй мөн цааш дамжуулахгүй аж.



Коронавируст халдварын өртөлтийн эрсдэлийг эрт мэдээлэх "COVID-19 ERSDEL" системийг гурав хоногт 300 мянган хүн гар утсанд суулгаж, тохируулжээ. Бусад улстай харьцуулахад богино

"COVID-19 ERSDEL" СИСТЕМИЙГ
ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Таны гар утас android үйлдлийн системтэй бол та гар утсандаа COVID-19 ERSDEL

"ХЭН ЦЭВЭР САЙХАН БИЧИХ
ВЭ" УРАЛДААН БОЛОВ



Зэвсэгт хүчний
065 дугаар анги

Хорооны төв болон байгууламж, тусгай ротуудын салаа, салбарын захирагч нарын дунд энэ сарын 9-22-ны өдрүүдэд хичээлийн конспект, төлөвлөгөөг "Хэн цэвэр сайхан бичих вэ" уралдааныг явууллаа.

Тус тэмцээнийг ЗХЖШ-ын даргын дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах, салаа, салбарын захирагч нарыг удирдах, манлайлах, заах арга барил эзэмшүүлэх ажлын дадлага

туршлагыг нэмэгдүүлэх, хичээлийн конспек, төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн гараар цэвэр бичиж хэвшүүлэх зорилгоор зохион байгуулсан юм. Тэмцээнд тус ангийн 253 дугаар тусгай ротын дэслэгч А.Азаяа, 085 дугаар ротын ахлах ахлагч Ц.Амараа нар бусдыгаа хошуучиллаа.

Ахмад З.АНХБАЯР

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ ИЛЭРСЭН
СУМ, ГАЛТ ХЭРЭГЛЭЛИЙГ
АЮУЛГҮЙ БОЛГОЛОО



Зэвсэгт хүчний
084 дүгээр анги

Тэсэрч, дэлбэрэх зүйлсийн хайгуул устгалын бүлэг ЗХЖШ-ын даргын тушаалаар Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд ажиллалаа.

Тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Баянмөнхийн ирүүлсэн "Манай аймгаас байлдааны болон сургуулийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйлс илэрлээ" гэсэн мэдээллийн дагуу долоон төрлийн 20 гаруй сум, галт хэрэглэлийг илрүүлж, аюулгүй болгов. Байлдааны зориулалттай 82 мм-ийн мина дөрөв, ПОМ3-2 явган цэрэг

эсэргүүцэх мина нэг, 73 мм болон 85 мм-ийн их бууны сумны хошуу нэг, 14.5 мм-ийн галт хэрэглэлийн сум нэг, сургуулийн зориулалттай 115 мм-ийн "Т-62" танкийн сум зургаа, 125 мм-ийн сум таван ширхэгийг эрэл хайгуулаар илрүүлж, аюулгүй болгосон юм.

Тус бүлгийнхэн Говьсүмбэр аймгийн иргэдийн амь нас, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болох тэдгээр сум, галт хэрэглэлийг илрүүлж, аюулгүй болгохоор орон нутгийг зорихын өмнө УОК-ын шийдвэрийн дагуу PCR шинжилгээ өгч, хариу сөрөг гарсны дараа явсан юм.

Ахмад Ч.НЯМСҮРЭН

ДЭЛХИЙ ДАХИНД

УКРАИНЫ ХИЛД ХУРАЛДСАН



Украины зүүн хилийн дагуу ОХУ-ын Воронеж, Крымд төвлөрөөд байсан Оросын цэргийн ихэнх хүчийг үндсэн байрлалдаа буцах тушаалыг тус улсын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу өглөө. Шойгу энэ талаар "Ийнхүү цэргүүдээ гэнэт төвлөрүүлж, богино хугацааны дотор идэвхжүүлсэн нь үр дүнгээ өгч, Орос орон болзошгүй тулаанд үргэлж бэлэн бөгөөд цэрэг эрс эрнэхөө төлөө хэзээд үнэнчээр зүтгэж чадна гэдгийг харууллаа. Украины хилийн дагуу цугларсан цэргүүд тулааны бэлэн

байдал хангах сургуулилтаа амжилттай дуусгасан тул аажмаар ийнхүү гэртээ харьж эхэллээ" хэмээсэн байна.

ОХУ-ын цэргийн эл гэнэтийн идэвхтэй үйл ажиллагаа Украины Киевт үймээн тарьж, барууны орнууд Путиныг дахин нэг эзлэн түрэмгийлэл хийх гэж байна хэмээн буруутгаж, олон улс Украины талд зогсохоо мэдэгдсэн ч ОХУ Украинтай байлдах зорилгогүйгээ удаа дараа тайлбарласан юм. ОХУ-ын цэргүүд ирэх сарын нэгэн гэхэд бүгд үндсэн байрлалдаа буцсан байх ажээ.